

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Лхагва гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:**

1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:**

4-18

---

**1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль  
хүчингүй болсонд тооцох тухай хуулийн  
төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн  
мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

4-18

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын  
04 дүгээр сарын 30-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 45 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 51.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Батцэцэг, Б.Бат-Эрдэнэ, П.Ганзориг, Г.Дамдинням, Ц.Мөнхбат, У.Отгонбаяр;

Чөлөөтэй: Д.Батбаяр, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, С.Ганбаатар, С.Замира, Б.Заяабал, С.Лүндэг, Р.Сэддорж, Б.Уянга, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа.

**Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Б.Бейсен, Т.Аубакир, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Л.Мөнхбаясгалан нар үг хэлэв.

*Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ц.Даваасүрэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “2025 оны 04 дүгээр сарын 01-ний” гэснийг “2025 оны 05 дугаар сарын 20-ны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 16 |
| Татгалзсан: | 12 |
| Бүгд:       | 28 |

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5-д заасны дагуу “Хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн саналаа тайлбарлаж үг хэлэв.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 7  |
| Татгалзсан: | 21 |
| Бүгд:       | 28 |

25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 28 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 28.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хороодоос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

*Уг асуудлыг 11 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 44 минут үргэлжилж, 45 гишүүнээс 27 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 18 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
10 цаг 34 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Даваасүрэн:** Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Өнөөдөр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаан хийж байгаа.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 45 гишүүнээс 23 гишүүн ирж, ирц 51.1 хувьтай байгаа учраас хоёр Байнгын хорооны хамтарсан 2025 оны 4 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудал дээр үү?

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эхэлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулъя. Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх ёстой. Тэгээд 2 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцүүлгийг явуулъя.

Эхний зүйл. 1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? 1 дүгээр зүйлтэй холбогдуулан шүү.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Алга байна.

Нэгдүгээр зүйлтэй холбогдуулан Чуулганы дэгийн тухай хуулийн 39.14-д заасан хугацаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Бямбацогтоос 1 санал ирүүлсэн байна. Тэгэхдээ энэ санал нь Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсон тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй байгаа тул санал хураалгах боломжгүй байгаа юм. Би саналыг та бүхэнд бас танилцуулах ёстой.

Алслагдсан бүс нутгийн иргэдийн амьжиргааг дэмжиж, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор баруун аймгуудын хилийн боомтуудаар импортын улаан буудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх гэсэн ийм заалт, ийм санал оруулж байгаа юм байна.

Тэгэхдээ энэ санал нь бидний хэлэлцэж байгаа хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй байгаа учраас Дэгийн тухай хуулийн дагуу хураалгах боломжгүй байна.

Өөр саналтай гишүүн байна уу 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад? Хугацаандаа санал өгсөн юм уу? Асуух асуулт юм уу?

Мэндсайхан гишүүний микрофоныг.

**3.Мэндсайхан:** Өглөөний мэнд хүргэе.

Гаалийн татварыг ингээд бид нар ингээд буцаагаад тэглэхинэ. Тэгэхдээ нэг ийм асуулт байна л даа. Энэ танайхаас ирүүлсэн Хөдөө аж ахуйн яамнаас гаргасан мэдээллээр нийтдээ өнгөрсөн онд 64000 тонн гурил импортоор орж ирсэн байна. Энэний чинь 30 хувь нь Сэлэнгээр буюу хойд талын боомтоор орж ирсэн байна аа, 2 боомтоор. Сүхбаатар боомт юу хоёроор.

Гол нь нөгөө миний хэлэх гээд байгаа санаа ОХУ-аас бид нар энэ гаалийн татварыг тэглэсэн асуудал бол ерөөсөө баруун аймгуудынхны хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын үнэ өсөөд байгаа учраас л ийм асуудал гаргаж байгаа юм. Улаанбаатар хот дахь үйлдвэрлэлээс гарч байгаа үнэ бол хямдхан байгаа 1500-аас 1800-гийн хооронд. Эндээс Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай руу тээвэрлээд очиход 1кг гурил яг дахин үнэ өсөж байгаа тээврийн зардалдаа.

Тэгэхээр энэ орж ирсэн статистик мэдээллээс харахад Баян-Өлгий, Увсын боомтуудаар орж ирсэн гурилын тоо ч Завханаар орж ирсэн гурилын импортын хэмжээ чинь нь 30 орчим мянган тонн л байгаа байхгүй юу. Тэгэхээр ингэж тэр бүс нутгийнхныг эргүүлээд гол нэрийн бүтээгдэхүүний үнийн хүндрэл, эрсдэлд оруулж байхаар хүнсний аюулгүй байдлаараа энийгээ зохицуулаад явчхаж болохгүй юм уу? Хүнсний аюулгүй байдлаараа баруун 5 аймаг дээрээ энэ импортын хөнгөлөлттэй нөхцөлийг нь Засгийн газар өөрөө шийдээд яваад. Тэгэхгүй бол одоо та нар гурилаас гадна ирэх жил зуд болбол бид нар дотоодын тэжээлгүй гээд дахиад энэ татварыг чинь нээх асуудал гарна шүү.

Тэгэхээр энэ зохицуулалтуудаа та нар Засгийн газрын тэр Ерөнхий сайдын ахалдаг Хүнсний аюулгүй байдлын зөвлөл байгаа шүү дээ энэ дээрээ зохицуулаад

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

явчих боломж нь байхгүй юм уу? Ингэж заавал энийг цуцлаад байх шаардлага байна уу л гэж?

**Ц.Даваасүрэн:** Санал, үг одоо явж байгаа байхгүй юу.

**3.Мэндсайхан:** Санал шүү.

**Ц.Даваасүрэн:** Санал хэллээ. Яагаад гэвэл асуулт дээр би асуухад 1 ч гишүүн гараа өргөөгүй алх тогшчихсон учраас саналаар явахаас өөр арга байхгүй.

Бейсен гишүүн санал хэлье. Аубакир гишүүнийг нэмчих.

**Б.Бейсен:** Та бүгдэд өглөөний мэнд хүргэе. Энэ гурилын импортын татварыг тэглэсэн цуцалсантай холбоотой бас дотоодын тариалалтын ажлыг бас дэмжихгүй бол болохгүй асуудал үүсээд байгаа.

Яагаад гэвэл тариалалт өнгөрсөн жил 57 хувиар буурсан. Энэ жил бас та тариаланчид маань хүлээж байгаа. Ноднин бид нар чинь баруун аймагт ер нь улсын хэмжээнд зудын байдалтай холбоотой гурил, тэжээлийн импортын татварыг чөлөөлсөн. Ноднин чөлөөлөхөөс өмнө 1 шуудай 50 кг-ийн гурил чинь 130000 болсон шүү дээ. Одоо 85000 төгрөгийн үнэтэй байгаа.

Тийм учраас энийг баруун аймаг дээр Энхбаяр сайд тусдаа арга хэмжээ аваад ер нь квот тогтоож өгсөн нь зөв байх. Баруун 5 аймагт. Цагааннуур боомт, Увсын Боршоо боомтоор орж ирээд гурил дээр квот тогтоож өгөөд наашаагаа оруулсан компани байвал хар дансанд оруулах хэмжээний арга хэмжээ авахгүй бол дахиад гурилыг нь өснө, тээврийн зардал нэмэгдэнэ. Тэгэхээр энэ дээр арга хэмжээ авч ажиллана уу гэдэг санал хэлье.

**Ц.Даваасүрэн:** Уг нь саналыг урьдчилж ирүүлэх ёстой. Тэгэхдээ одоо яах вэ чухал асуудал хэлэлцэж байгаа учраас санал хэлүүлчихье. Аубакир гишүүн.

**Т.Аубакир:** Баярлалаа. Энэ гурилын үйлдвэрлэлийн асуудал дотоодын хүнсний хангамжийн хүрээнд нэлээн нухацтай авч бас үзэх ёстой асуудал юм байгаа юм. Тэгээд энэ аливаа өргөн хэрэглээний барааны татварыг Улсын Их Хурал дээр энэ галтай сэдвийг авчраад, нөгөө улс төрчид маань ард иргэдэд таалагдах гээд тэрнээсээ болоод үндэсний үйлдвэрлэлээ, зарим нь үндэстний хэмжээнд л юм ярьцаагаад л байх юм. Энийг Энхбаяр сайд сая Мэндсайхан сайд бас хэллээ шүү дээ. Зөв санаа шүү дээ. Энэ татварын асуудлыг ингээд тохируулга хийчхэж болох зүйлийг заавал Улсын Их Хурал дээр чирч ирээд байх хэрэг байгаа юм уу? Одоо цемент дээр бид нар бол жишээлбэл тэгж л алдсан шүү дээ. Хилийн цаана үнэхээр хямдхан байгаа л юм бол нөхөр цемент үйлдвэрлэгч ээ хилийн цаана тэдэн төгрөг байна. Хэрвээ үнээ буулгахгүй бол бид нар гаалийнхаа татварыг буулгаад гааль хилийнхээ крантыг нээлээ. Үнэ нь тэнцвэржээд ерөнхийд буцаагаад татварыг нь тавиад л ингэдэг энэ зохицуулалтыг нь энэ Засгийн газарт бол нөхчихмөөр юм байгаа юм. Улсын Их Хурал дээр авчраад л 126 гишүүн болчихсон. Үгүй ээ мэдээжийн хэрэг тойргийнхоо иргэдийг байдаг ч юм уу, энэ Монголын ард иргэдийг хямдхан хүнс хэрэглээсэй, тэрийгээ дотоодоосоо хангадаг болчих юм сан. Энэ чинь аль энэ улс эх орон энэ Засгийн газар, Улсын Их Хурал тэрийг хамгаалах л ёстой шүү дээ.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Энэ галтай сэдвийг түрүүн Энхбаяр сайд чуулган дээр аягүй зөв хэлээд байна лээ. Энэ эрхийг нь цемент энэ гурил мэтийн ийм зүйлүүдийг Засгийн газар шууд тэндээ тохируулга хийчихдэг тэр зохицуулалтыг хийх хэрэгтэй. Энэ зүгээр энийг ойлгохын тулд заавал Харвард төгсөх шаардлагагүй шүү дээ. Гадаа хилийн цаана хэдэн төгрөг байгаа юм байна, дотооддоо нэмчихлээ. Нөхөр Бакир чиний гурил үнэтэй байна аа. Бид нар крантаа нээнэ шүү всё. Цемент дээр бид нар тэгж чадаагүй учраас алдсан шүү дээ тухайн үед.

Дээрээс нь гурилын үйлдвэрүүд ингээд байнга туслалцаа, дэмжлэг, тэтгэлэг аваад байдаг гээд хэлээд байх юм. 250 орчим тэрбум төгрөг гурилын үйлдвэрүүд авчихсан юм аа эд нар ерөөсөө болохгүй байна бид нар гаднаас гурил оруулъя. Тэгвэл хайран 250 тэрбум төгрөг. Тэр гурилын үйлдвэрүүдийг тэгвэл яах гэж дэмжсэн юм анхнаас нь. Дотооддоо бид нар айлаас шанага гурил гуйхгүй хэмжээнд будаагаа тариад гурилаа хийчихдэг, малынхаа тэжээлийг бэлдчихдэг байя л гээд л явж байгаа юм байгаа биз дээ. Энийг заавал Улсын Их Хурал дээр авчраад л тэгээд л иргэдэд таалагдах гэсэн поп поп юмнууд яриад. Үгүй ээ чи энийг ойлгохын тулд Харвард ч юм уу, ийм юмаар төгсөх шаардлага байхгүй шүү дээ. Энэ эрхийг нь Засгийн газарт нь өгөөд л тэрийг нь шинжээч, судлаачид нь байж байна, хилийн цаана тэдэн төгрөг байгаа юм байна, дотоодод бид нар монопол болчихлоо. Олигопол болчихсон юм бол бид нар энэ крантыг нь нээчихье, хилээ онгойлгочихье, татвараа нэмчихье. Үгүй ээ энэ зохицуулалт руу бид нар явах хэрэгтэй байна шүү дээ.

Ер нь дотоодынхоо хэдэн үйлдвэрлэл янз бүрийн дөнгөж бизнес эрхэлж эхэлж байгаа, тэр үйлдвэр байгуулж байгаа хүмүүсийг ад үзээд л, айлын хүүхдийг шүтсэн өөрийнхөө хүүхдийг ад үзсэн байдалтай ингэж байгаад байж болохгүй шүү дээ. Нэг л их ард иргэддээ, ард түмэндээ хайраа зарлацгаагаад л.

Тийм учраас энэ галтай сэдвийг байн байн Улсын Их Хурал дээр авчраад баймааргүй байна Даваасүрэн дарга аа. Энэ чинь өнгөрсөн 24 оны сүүлээр юу боллоо. Одоо энэ чинь дахиад буцаад татвар тавих гээд л. Тийм учраас энэ энгийн асуудлыг бид нар тэр Засгийн газарт нь өгөөд л, Засгийн газар нь тэр хажууд нь тохируулагч агентлагууд нь байж байна. Мэдээлэл, шинжилгээ, судалгаа хийдэг гаалийн байгууллага, бусад Засгийн газарт зөвлөдөг зөндөө л хүн байдаг байлгүй дээ. Дотоодод үнэтэй байгаад байна. Хилийн цаах нь талд хямдхан байгаад байна. Энийг оруулаад гаалийн татвараар нь ингээд зохицуулчихъя.

Хоёрдугаарт бид нар ярихаас өөр арга байхгүй. Улаанбаатар хотоос ихэнх үйлдвэр Улаанбаатар хотод төвлөрсөн. Баруунтуруун дээр байгаа тариалалтыг түшиглээд гурилын үйлдвэр байгуулагдвал сайн байна. Тэр болтол баруун 3, 4 аймаг чинь 1700км гурил тээвэрлэж тийшээгээ вагоноор тээвэрлэх боломж байхгүй. Авто тээвэр хамгийн үнэтэй тээвэр. Нэгэнт тэр Чойжилсүрэн сайд аа Увс руу энэ Улаанбаатар хотоос зөөж байхаар тэр баруун аймгийнх нь квотыг нь өнгөрсөн жил бол Болорчулуун дарга аа, Энхбаяр сайд аа 15 000 тонн, Увс аймаг 480 тонн сардаа, Ховд аймаг чинь 420 тонн, Баян-Өлгий аймаг 520 тонн, жилдээ 15000 тонн л гурил иддэг юм. 1700км зөөх үү, 650км Горналтаскийн бүс районоос оруулж ирэх үү? Энэ аягүй энгийн л тооцоолол баймаар юм.

Тэгээд энэ зэргийг нь ингээд тооцоод тэр баруун аймгийнхан цаанаасаа хямдхан гурилаа оруулаад ир энэ боломжийг нь бүрдүүлж өгье. Энэ гурилын



2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

үйлдвэрүүдийг худалдан авагчтай байлгахын тулд төвийн бүс район, хангайн бүсийн аймгуудад энэ дотоодынхоо гурил хуулиар хангая. Их л энгийн л баймаар юм энэ чинь. Би их олон сургууль төгсөөгүй л дээ гадаад, дотоодод. Энэ чинь бодоход тийм аягүй энгийн зүйл биз дээ. Энэ галтай сэдвийг Улсын Их Хурал дээр авчраад л ингээд л тал тал болоод л, гайхацгаагаад л, шагширцгаагаад л айлын үйлдвэрлэгчдийг шүтсэн, өөрийнхөө хэдэн үйлдвэрлэгчдийг ад үзсэн байдалтай. Үгүй ээ тэгвэл тэр гурилын үйлдвэрлэлдээ ажиллуулахгүй, ашигтай ажиллуулахгүй юм бол 254 төгрөгөөр яах гэж хөрөнгө оруулалт хийсэн юм ер нь?

Ер нь одоо тэр хэдийгээ ад үзэж хаяад л, дэвсэлж хаяад л хайран улсын мөнгө өгсөн. Арай гэж босгосон 20, 30 жил явж байж босгосон гурилын үйлдвэрүүд энэ гурилын үйлдвэрүүд чинь 6-9 гурилын үйлдвэр ажиллаж байгаа. Тэр дотор бас тогтмол ажиллаж байгаа 4-5 л байгаа байх. Тэгээд л гаднын тэр түү стандарт, технические условие, ГОСТ ч стандарт ч биш. Та нар баруун аймгуудын захуудаар яваад үзээрэй технические условие гурилыг ГОСТ ч.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Санал хэллээ.

Аубакир гишүүн ээ энэ чинь миний санаачилсан хууль биш л дээ. Засгийн газар санаачилсан учраас. Тэгээд нэгэнт өргөн баригдсан бол дэгийнхээ дагуу би заавал хэлэлцэх ёстой.

Идэрбат гишүүн. Ер нь байна шүү дээ саналаа урьдчилж ирүүлэх ёстой ёстой юм байна лээ шүү. Тэгэхдээ Идэрбат гишүүн. Санал шүү. Үг биш шүү. Үг биш шүү тийм.

**Ц.Идэрбат:** Байнгын хорооны гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Өнөөдрийн бидний энэ ярьж байгаа асуудал яах вэ дээ тэгээд төр гээд нэг өглөө босоод л нэг юм ярьдаг тийм л хэлбэрийн маань нэг л болж байна шүү дээ наадах чинь ер нь.

Жилийн өмнө тэгээд гурилын энэ татварыг яах гэж тэглэсэн юм бэ гэвэл гурилын үйлдвэрүүд нь тамтаггүй үнээ нэмээд байнаа үүнийгээ дагаад гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ нь өсөөд байнаа, үүнийгээ дагаад инфляц нь өндөр гараад байнаа, үүнийгээ дагаад Монголбанкны бодлогын хүү нь өндөр болоод байнаа, үүнийгээ дагаад арилжааны аж ахуйн нэгжүүдэд өндөр хүүтэй хүү очоод, зээл очоод байна, зээл ховордлоо. Үгүй ээ ердөө үндсэн шалтгаан энэ шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт тариаланчдын бас баахан зовлон ярьсан шүү дээ. Тарьдаг, ургуулдаг, авдаггүй, үйлдвэрүүд нь хажуудаа лабораторитой, чиний тэнцэхгүй гээд ингээд байдаг. Одоо энэ тарьсан тариагаа бид яах вэ гэдэг ямар ч мухар, шийдвэр байхгүй ийм мухардал байдалд орчихсон байсан.

Тэгээд бид өнөөдөр ингээд энэ асуудлыг ярихдаа саяын ярьсан юмнуудаасаа нэгийн ч шийдэл байхгүй зүгээр л хэдүүлээ татвараа нэмье ээ, болохоо байлаа гээд ингээд байгаад л би гайхаад байгаа юм л даа. Тэрнээс үндэсний үйлдвэрлэгчид, энэ тариаланчид, цаг хугацаа энэ бүх зүйлүүд хэцүү байгаа гэдгийг ойлгож байна. 90-ээд оны үед ясны гурил идэж байсан тэр цаг үеэ бидний хүүхэд нас өнгөрсөн. Ясны гурилаа хаачихад гурилгүй болж байсан түүх бидэнд бас байгаа.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Гэхдээ энэ нь нөгөө Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар гэж төрийн нэг институт нь энэ чинь үнээ хуйвалдаж нэмээд байна шүү дээ гээд ингээд хэлээд байсан тийм юмнаас л үүдэлтэй шүү дээ. Тэгээд бид нар тэрийг нь алийг нь ч мухарлаагүй. Хуйвалдаж нэмсэн ч юм уу, эсвэл нэмсэн гэж тэд нарыг хохироосон юм уу, нэр хүндэд нь халдсан юм уу алийг нь ч шийдээгүй. Зүгээр л одоо тэгээд л татвараа нэмье ээ. Тэгээд одоо энэ гурилын үйлдвэрийнх нь тэр, тариаланчид тэр цаана нь дахиад айдас байгаа юм байна лээ шүү дээ.

Хэрвээ эрүүл зах зээлээрээ яваад гурилынх нь үнэ өсөхөд дахиад энийгээ хаачихвал бид яах вэ, дахиад нээчихвэл яах юм? Яг тэр гишүүд тойргоороо ажиллахаар очсон сум болгонд нь очоод гурилын үнэ 1 дахин нэмэгдчихлээ гэдэг үгийг сонсоод ирсэн гишүүн бол энэ чуулган дээр бол наад татварыг чинь дахиад тэглээ ээ гэдэг асуудал хэн нэгнээс гараад л ирнэ.

Тийм учраас тэгээд би бол ямар ажил, санал гаргах гээд байна гэвэл Төсвийн байнгын хороотой цуг байна. Энэ асуудлыг бид ер нь ингээд цэгцлэхгүй юм уу, тодруулахгүй юм уу Даваасүрэн дарга аа? Тодруулахгүй юм уу? Нэгдүгээрт тэр хуйвалддаг, үнэ нэмдэг юм байдаг бол тэрийг зогсоомоор байна. Хуйвалдаж нэмээгүй байдаг бол тэр гурилын үйлдвэрүүдийнх нь нэр төрийг ч гэсэн сэргээмээр байна шүү дээ. Ийм 2 асуудал байгаа юм.

Тэгээд яах вэ дээ энэ чинь гурилын үнэ л гэж яриад байгаа болохоос биш энэ чинь боов боорцог, гоймон, нөгөө хэрэглээний, сагсны нэлээдгүй олон бараа, бүтээгдэхүүн нь энд явчихдаг. Сумын төвийн цуйвангийн үнэ хүртэл тэгээд тэр инфляцын тэр юунд ороод явчихдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд одоо инфляц нь дийлэхээ болилоо гэдэг ийм юм руу явчих вий.

Тийм учраас би бол эхлээд энэ төрийн бодлого гэж байгаа бол энийгээ цэгцэлмээр байна гэсэн ийм л санал. Та бол түрүүчийн Байнгын хорооны хурал дээр газар тариалан гурилтай байхыг бол дэмжиж байна. Гэхдээ хуйвалдаж үнэ нэмдэг асуудлыг бид яах вэ гэдэг асуудлыг бас ярьж байна лээ шүү дээ. Замбараагүй нэмээд байж болохгүй шүү дээ гэж.

Жишээ, дараагийн нэг юм бол жишээ нь бид ингээд яг яамны тайлбарт итгээд л бүх юмаа хийгээд байх юм уу? Үйлдвэрүүд хаалгаа барьж байна, үйлдвэрүүд цөөрөөд байна, хүчин чадлаа бууруулж байна л гэж тайлбарлаад байдаг. Зүүн бүсэд тэр Дорнод гурил 25 хувиар хүчин чадлаа нэмж байна лээ шүү дээ.

Яагаад гэвэл Болорчулуун дарга тийм юм ярьж байна лээ шүү дээ. Өвөл 2 сард бид нарыг очиход. Манай борлуулалт бол сайн байгаа, дийлэхээ болиод байна. Одоо 25 хувиар хамгийн сүүлийн үеийн Европын технологи авчраад суурилуулж байна гэж байгаа юм. Яам нь бол бүх үйлдвэрлэл ингээд л элгээрээ хэвтэх гэж байгаа юм шиг л юм яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид газар тариалантай байх хэрэгтэй, гурилтай байх хэрэгтэй. Нөгөө талдаа энэ чинь эрүүл зах зээл явах ёстой. Энийг яаж хагалах вэ гэж ярихын оронд зүгээр л нэг бол ингээд тас хаадаг, нэг бол нээдэг. Тэгэхээр би бол Төсвийн байнгын хороотой хамтарч хуралдаж байгаа дээр энэ дээр ч гэсэн бас жоохон тайлбартай юмтай байхгүй бол магадгүй өнөөдөр ингээд гурил

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нэмэгдэхгүй байна гэж яриад байгаа нь магадгүй энэ хуулийн ач холбогдол ч байхыг үгүйсгэхгүй ийм л зүйл байгаа шүү дээ. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Гишүүдийн хэлээд байгаа үнэхээр бас бодууштай саналууд. Улс төрөөсөө шалтгаалаад татвар тогтворгүй байх юм бол гаднын хөрөнгө оруулагч нар, дотоодын үйлдвэрлэгч нарт маш хүнд тусаж байгаа. Ер нь зүгээр гурилын үнэ өссөн асуудал бол ерөнхийдөө улс төр байсан гэж ойлгож болно.

Яагаад гэвэл энэ Украин, Орос хоёр чинь бол дэлхийн энэ гурил, будааны зах зээлийн 50 хувь байхгүй юу. Энд дайн үүсчихээр дэлхийд угаасаа яасан асуудал үүссэн. Африк, Араб шиг манайд гурилын хомсдол үүсээгүй шүү. Энэний гол үүсгээгүй тэр буян үйлдэгч нар бол газар тариалан эрхэлж байгаа улсууд, үндэсний үйлдвэрлэгч нар. Монгол ардын нэг үг бий шүү дээ. Айлаас гуйхаар авдар ух атга гурил гарна гэж. Тийм учраас энэ зарчмаар явах ёстой, үндэсний үйлдвэрлэгчдээ бид нар хамгаалах ёстой.

Хамгийн гол нь зүгээр тэр монопол зах зээл үүсгэх гээд байгаа бол тэр монополын эсрэг байгууллагуудаа л ажиллуул л даа. Энд орж ирээд л ингээд л хэрүүл хийгээд л, эндээс бүх юмыг шийдэх юм шиг ойлгоод л, тэгээд л татвараа байн байн өөрчлөөд л ингээд л байх юм бол энэ газар тариалан гурил үйлдвэрлэдэг асуудал бол хүнд цохилтод ороод байхгүй болох ийм эрсдэлтэй.

Бид нар хэзээ ч дэлхийн 50 хувийг хангаж байгаа ОХУ-тай өрсөлдөж чадахгүй. Тэрийгээ ойлгох хэрэгтэй. Нэг ёсондоо сумын начин л дархан аваргатай би үзэлцэнэ ээ гээд байгаатай ялгаагүй шүү дээ энэ чинь. Барилдана аа гээд байгаатай ялгаагүй байхгүй юу. Тийм учраас энэ зүйлээ бид нар бас ухаараад ингээд явах ёстой. Нэгдүгээр асуудлыг хэлэлцэж дууслаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өгөөрэй.

Энэ цаг хугацааны асуудал юм байгаа юм шүү уг нь. Ганхуяг гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн. Наранбаатар гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая. Тийм өргөн барьсан хууль 4 сарын 1-нээс үйлчлэхээр заагдаад ороод ирчихсэн. Хэлэлцэж байгаа цаг хугацаа маань тэрнээсээ хэтэрчихсэн.

Тийм учраас хууль батлагдаад тэгээд бас тодорхой институтүүд түүнд тодорхой үнэлгээ хийж үзээд хоригийн тухай асуудал байдаг. Энэ юмнуудаа тооцож хэдүүлээ энэ цаг хугацааг хойшлуулах ёстой юу гэдэг нэг ийм асуудал байгаа юм.

Хоёрдугаарт би нэгэнтэй асуулт асууж байгаа юм нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Гаалийн татвар гэдэг бол ер нь яг зүгээр ерөнхий ухагдахуун талаасаа авч үзэх юм бол дотоодын зах зээлээ хамгаалаад үндэсний үйлдвэрүүдээ дэмжээд тэр салбарт ажиллагсдыг урам зоригтой ажиллуулах ерөөсөө ийм л тарифын бодлого байхгүй юу. Энэ бодлогоор оролдохгүйгээр хангалт, нийлүүлэлт, үнэ ханшийн асуудлаа зохицуулах бололцоо бидэнд байгаа. Үндэсний хүнсний

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

аюулгүй байдлын зөвлөл дээр яриад аль боомтоор хэдий хэмжээний гурил оруулах вэ гэдэг квотоо тогтооход л асуудал байхгүй байхгүй юу. 5 хувийн тариф гэдэг бол яг нарийндаа үнэнд тийм их хүчтэй нөлөөлөл өгөхөөр тариф биш шүү.

Ийм учраас энэ талаас нь харж би Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг энэ гаалийн тарифын бус дотоодын тэр тарифуудаараа, тарифын бус хязгаарлалтуудаараа асуудлуудаа зохицуулаад энэ үнэ өртөг өсгөхгүй байх, хангалт, нийлүүлэлтээ хэвийн байлгах энэ ажил руугаа шамдаж орох ёстой шүү гэдгийг зориуд би хэлмээр байгаа юм.

Энэ шийдвэрийг гаргаснаараа бараг 100 жил, яг аян өрнүүлээд шинжлэх ухааны үндэстэй салбар болгоод явсан газар тариалангийн салбар бол 66 дахь жилдээ явж байх шиг байна. Тэгээд энэ салбарын хамт олныг бас итгэл төгс энэ тариалалт руу нь оруулах хэрэгтэй байгаа юм. Бид энэ үндэсний үйлдвэрлэл, хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай яриад байгаа улсууд төр нэгдсэн бодлоготой л явах ёстой. Нэг газраасаа бодлого орж ирээд л хэдүүлээ хүнсний хангамж, аюулгүй байдал гээд л үндэсний хэмжээний том хөтөлбөр, аяныг өрнүүлээд л яваад байдаг.

Нөгөө талдаа нөгөөдүүлийнхээ эсрэг маягтай төрийн бодлого, шийдвэр гаргаад явахаар чинь төрийн бодлогын нэгдмэл байдал хангагдаж чадахгүй байгаа юм. Тэгээд энэ талаасаа харах ёстой. Манай гишүүдийг би энэ талаасаа бодлого юмандаа илүү нухацтай хандах байх гэж ойлгож байна. Энэ гаалийн тариф гэдэг бол яг нарийндаа үнэ зохицуулдаг зүйл биш ээ. Үндэстэн өөрийнхөө аюулгүй байдлыг хамгаалдаг, зах зээлээ хамгаалдаг, өөрийнхөө үйлдвэрийг хөгжүүлдэг ийм л тарифын бодлого байхгүй юу. Үүгээрээ л би зохицуулах ёстой л гэж ойлгоод байгаа.

**Ц.Даваасүрэн:** Эхний тэр цаг хугацааны хувьд бол би санал гаргаад хураалгачихна. Хоёр дахь санал бол маш чухал санал байна. Манай Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамынхан анхаараад явна биз. Бид чинь хэрүүлд сайн, бодлогод муу үндэстэн болчихоод байна шүү дээ.

Дараагийнх нь Мөнхбаясгалан гишүүн санал шүү дээ. Үг, асуулт асуулт.

**Л.Мөнхбаясгалан:** Асуулт аа, үг биш юм уу? Байгаа гээд байсан шүү дээ. Минут явчихлаа. Энэ гурилын импортыг улаан буудайн үнийг тэглэсэн нь тухайн үеийн сонгуулийн Пи Ар л байсан шүү дээ. Сонгууль дээр санал авахын төлөө л энийг хийсэн. Яагаад их хурлаар хэлэлцүүлсэн бэ гэвэл тэн дээр юм ярьж, оноо авах гэсэн гишүүд байсан. Өмнөх 76-тай парламентын л үйлийн л байна шүү дээ. Одоо тэгээд энэ дээр юм ярихаар үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжихгүй байна. Үндэсний үйлдвэрлэлээ юу гэж доош нь хийх гээд байгаа юм, одоо энэ татварыг нь тавих ёстой гэдэг юм руу явж байна л даа. Тухайн үед хэн хэн юу ярьж байсан, яаж байсан гэдгийг нь бас гаргаад бүүр нэвтрүүлэг хийчихмээр санагдаад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ чинь цахилгааны үнэ нь нэмэгдчихсэн шатлалтайгаар 57 хувь, инфляц 9.2-той болчихсон дахиад хөдөлнө. Зээл, Монголбанк бодлогын хүүгээ нэмчихсэн. Тэгэхээр энэ чинь үнэ нь нэмэгдэнэ л дээ. 5 хувь гэж яриад байх юм. Энхбаяр сайдын мэдээлснээр бол тээвэрлэлт жижиглэнгийн худалдаан дээрээ 30-40 хувиар үнэ нь өсөөд байгаа юм гэж байгаа шүү дээ. Анх энэ хуулиа гаргахдаа

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дотоодын гурилын мафитай тэмцэж тэд нарыг дарж авч сургаж өгөхөөр л баталж байгаа гэсэн хууль баталсан. Одоо тэгээд тэр мафия дарчихсан, юундаа хүрчихсэн гээд байх шиг байна. Би бол энийг тийм гэж бодохгүй байна.

Тэгэхээр ингээд сонгууль дөхөхөөр гэнэт зах зээл рүү бэлэн мөнгөний нийлүүлэлт хийдэг, сонгууль дөхөхөөр байж болохгүй сонин сонин шийдвэр гаргадаг. Энийгээ өмнөх 76 дээрээ орхиод одоо жоохон өөр юм хараад явмаар байна. Одоо тэгээд энэ хуулийг нь дэмжихгүй гэхээр үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжээгүй нөхөр болж хувираад байдаг. Тэгсэн хэр нь яг дотоодын гурилын мафия дарчихсан юм уу гэхээр дарсан юм юу ч байхгүй. Тухайн үед ярьж байсан хүмүүс өнөөдөр шал өөр юм яриад эх оронч болчихсон үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжиж байгаа байхгүй юу. Би бол Энхбаяр сайдтай санал нэг байгаа. Үндэсний үйлдвэрлэгч их нэмээд л мафа эд нар болоод байсан юм байхгүй. Үнийн өсөлт нь ерөөсөө л тээвэрлэлт, жижиглэнгийн худалдаан дээр байгаа. Одоо цахилгааны үнэ өсчихсөн, одоо 10 сараас дулааны үнэ өснө шүү дээ. Тэгэхээр дахиад л нэмэгдэнэ шүү дээ. 5 хувь биш л дээ. Өшөө нэмэгдэнэ гэсэн үг. Тэгэхээр ингэж сонгуульд тохируулж хууль хийдгээ, тэрийгээ тохируулж Улсын Их Хурал дээр ярьж гоё гоё оноо авдгаа л больчихмоор байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Асуулт маягийн бараг үг хэлчихлээ тээ? Харин наадах чинь их чухал санаа байна шүү. Ер нь энэ өмнө нь юу ярьж байсан, дараа нь юу ярьж байсныг ингэж харьцуулж ярьдаг ийм нэвтрүүлэгтэй болох юм бол бас том дэвшил болох байх.

Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Би Энхбаяр сайдаас 1 асуулт асуух гээд байгаа юм. Бид нар нэг бол татваргүй болгоно. Нэг бол татвартай болгоно гээд тэгээд байнгын ийм 2 туйлын хооронд ингээд гүйгээд байгаа байхгүй юу.

Монгол Улс бол өөрөө өргөн уудам нутагтай. Энхбаяр сайдын хэлснээр бол энэ тээврийн зардлууд нэлээн том жин дардаг гээд ярьж байгаа юм. Ургац бол жил болгон өөр гардаг. Энэ дээр бол цаг агаарын нөхцөл байдал ч гэсэн нөлөөлж байгаа. Цаг агаарын нөхцөл байдлаасаа болоод зарим ургац бол гурил хийх тохиромжтой байдаг, зарим нь болохоор тэр тэжээл рүүгээ яваад байдаг. Тийм ч учраас зарим зарим жил бол энэ гурилын үнэ өсдөг, эсвэл улаан буудайны хомсдол бий болдог гэж ойлгодог.

Тийм учраас бид нар энэ тарифын зохицуулалт хийх эрхийг нь ер нь Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам Засгийн газарт эрхийг нь олгочихвол яасан гэж бодоод байгаа юм. Бүсчилсэн манай Монгол Улс бол бүр өргөн уудам нутагтай болохоор баруун бүсэд жишээлбэл тэр улаан буудай нь бага ургасан бол эсвэл гурилын шаардлага хангахгүй байвал импортлох квотыг нь өгчихдөг. Тарифгүй импортлох квотыг нь, эрхийг нь өгчихдөг. Зарим газарт нь бол тэр тарифаараа явчихдаг. Иймэрхүү зохицуулалтын шинж чанартай юмаа бид нар бас оруулж ирэхгүй бол. Хүнс бол энэ чинь угаасаа инфляцад байнга авдаг, ард иргэдээсээ маш их дарамттай байдаг ийм бүтээгдэхүүн байхгүй.

Дээрээс нь манай үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой. Тэгэхээрээ бид нар гол тэр тариалангийн бүс нутаг, эсвэл гол тэр хүнсний үйлдвэрүүдийгээ цохилтод оруулахгүй байх бодлогоо авч явдаг. Улаан буудайны гурилын үнэ өсөөд

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байвал тэр газарт нь бид нар квотоор нь, татварын тэр бодлогоор нь, тарифын бодлогоор нь дэмжээд өгчихдөг иймэрхүү уян хатан байдлаар энэ Засгийн газарт эрх өгчхөж болдоггүй юм уу гэдэг л байдлыг асуух гээд байгаа юм л даа.

**Ц.Даваасүрэн:** Энхбаяр сайдын микрофоныг өгье. Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

**Ж.Энхбаяр:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Хүнсний тухай хууль гэж байгаа. Үүгээр гол асуудал зохицуулж байсан. Хүнсний аюулгүй байдлын зөвлөл гээд Ерөнхий сайд хариуцаж стратегийн гол хүнснийхээ үнэ, тогтвортой байдал, нийлүүлэлт дээр ийм хурдан, шуурхай арга хэмжээ авдаг байсан. Сая улаан буудай гурил дээр Их Хурлаар оруулаад татвар тогтоогоод ингээд түгжээд хаячихаар тэнд хурдан маневртай явж байсан өөрчлөлт хэрэгжихээ болчихож байгаа юм. Одоо энэ хуулийг буцаагаад хүчингүй болгох асуудал ингээд батлагдвал өмнөхөөрөө л Засгийн газар яг шатах, тослох материал дээр боомтоор нь, онцгой албан татвараар нь нөгөө зохицуулалт нийлүүлэлтээ хийдэг шиг л хийгээд явах бүрэн бололцоотой буюу тэгж хийж явсан зүйл.

Анхны хуулиа манайхан буруу ойлгоод байх шиг байгаа юм зарим улсууд. Яам бол хүндрэл үүссэн байна. Хангалтыг тогтворжуулахын тулд баруун бүсээр 25000 тонн гурил оруулж ирье гэдэг л хуулийн төсөл байхгүй юу. Тэрийг нь хязгааргүй болгоод, тэжээл болгоод, улаан буудай болгоод хязгааргүй бүх боомтоор тэг гээд хугацаагүй энэ Их Хурал дээр өөрчлөлт явуулаад орхичихсон юм. Тэгснээрээ нөгөө анхны орсон үзэл баримтлалаасаа шал өөрөөр хууль нь гараад ингээд үүссэн үр дагавар маань энэ.

Тэгэхээр яам бол өөрөө зохицуулалтаа хийгээд явах бүрэн бололцоотой зүйл. Тэгэхээр ахиад хэлье үгсэн хуйвалдсан зүйл нотлогдсон, тогтоогдсон зүйл байхгүй шүү. Энэнтэй холбоотой ямар нэгэн хууль шүүхийн байгууллагын шийдвэр гарсан зүйл байхгүй. Хамгийн их хэрэглэж байгаа 80 хувь болж байгаа 1 дүгээр гурил 1500-2000 төгрөг дотор л байна үйлдвэр дээр. Үйлдвэр болгон дүүрэн гурилын илүүдэлтэй, бүтээгдэхүүн хангалттай байна.

Худалдааны асуудал байна. 30-40 хувийн нэмэгдэл алслагдсан зайн бүстэй холбоотой асуудал байна. Монгол Улсад худалдааны хуульгүйгээр энэ худалдааны зохицуулалт ерөөсөө явахгүй байгаа юм. Хууль алга. Тэгэхээр энэ дээр бид цаашдаа их анхаарах.

Хоёрдугаарт жил болгон 100000 тонн улаан буудай авч улсын нөөц бүрдүүлэх зайлшгүй шаардлага. Энэ нь өөрөө тогтвортой байдлаа хангах гол суурь нь тэр юм. Нөгөө шатахууны нөөц бүрдүүлдэгтэй адилхан улаан буудайн нөөц бүрдүүлээд л, хямд үед нь нөөцөө дүүргээд л үнэтэй үед нь нөөцөөсөө гаргаж өгөөд байвал энэ гурилынхаа үнийг бид нар тогтмол бариад байх тэр бас бодлого байх ёстой.

Тэгэхээр тэр бодлогыг бас өнгөрсөн төсөв дээр хасаад хаячихсан. Тэгэхээр бид 26 ондоо оруулна. Энэ жилийнхээ 25 оны ургацаас бид нар 100000 тонны улаан буудайн нөөц бүрдүүлээд л ингээд жил болгон л авдаг болчихвол ингээд тогтвортой байдлаа хангаад явчих юм.



2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Ц.Даваасүрэн:** Тийм тийм. Энхбаяр сайд хэлээд байгаа юм. Би бол яг энийг түүхийг нь сайн мэдэж байна. Тухайн үед би Засгийн газрын гишүүн байсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нь энийг эсэргүүцээд дийлээгүй байхгүй юу. Яг үнэндээ бол зүгээр баруун аймагт дэвших гэсэн улсуудын л санаа байсан шүү дээ.

Гэхдээ Их Хурал 76-уулаа мөртөө бие даасан толгойгүй байдаг нь л гай л энэ байхгүй юу. Ганц хүн 2, 3 хүний саналыг 76-уулаа дэмжээд сууж байгаа нь өөрөө хохь нь байхгүй юу. Толгойгүй, морь унасан толгойгүй хүмүүс энд их суудаг учраас тэгж байгаа байхгүй юу.

Наранбаатар гишүүн асуулт асууя.

**Н.Наранбаатар:** Өнгөрсөн жил энэ гурилын импортыг тэглэдэг асуудал улс төрийн шинжтэй, сонгууль угтсан гээд ингээд ярьж байна. Тэгээд гурилын үнэ бодитойгоор бас энэ хууль хэрэгжээд буурсан уу гэвэл буурсан. Тухайлбал, говийн бүсэд яг ноднин өдийд 1 кг 1 дүгээр гурил 3100 төгрөг байсан бол яг өнөөдөр 2840 төгрөг байгаа юм. Тэгэхээр энэ хууль 1 жилийн хугацаанд хэрэгжихэд лав говийн бүсэд 5.6 хувиар кг гурилын үнэ буусан байгаа шүү дээ. Тэгэхдээ хоёр талтай л даа. Нэг талаасаа үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ, татварыг сэргээнэ.

Нөгөө талаасаа хамгийн эцсийн эцэст иргэд маань хямдхан л гурил, бараа, бүтээгдэхүүн авч байх ёстой шүү дээ зорилго нь. Тэгээд хоёр талтай асуудал. Тэгэхээр үүнийг явцын дунд нь тухайн цаг үеийнхээ байдлаас болоод зохицуулж байдаг тийм эрхийг нь Засгийн газарт өгчихөд болохгүй юм уу? Заавал энийг ингээд хүчингүй болгоод орхих биш, хүчингүй болгоод тэгээд Засгийн газарт цаг хүндэрсэн үед малын тэжээлийн татварыг тэглэдэг эрх, мөн бас КОВИД шиг ийм цаг үед гурилынхаа татварыг тэглэдэг ийм эрхийг нь өгөх тийм боломж байхгүй юм уу сайд аа?

Жишээ нь, малын хөлийн татвар байгаа шүү дээ. Хонин толгойд 0-2000 төгрөг гээд хуулиараа тогтоочихсон. Тэрийг нь аймгийн иргэдийн, сумын иргэдийн хурал нь 2000 байх юм уу, 1000 төгрөг байх юм уу, 5000 байх юм уу гэдгээ ингээд тухайн үедээ шийдээд ингээд явчихдаг. Өөр өөрийнхөө онцлогт тохироод, тохируулаад.

Тэгэхээр зэрэг яг энэ шиг ингээд засагт эрхийг нь өгөөд ган зуд боллоо гэхэд малын тэжээлийнхээ импортын татварыг тэглэхдэг. КОВИД шиг ийм нөхцөл байдал, хил, гааль, боомтын асуудал үүслээ гэхэд гурилынхаа татварыг тэглэхдэг ийм эрхийг нь өгөөд цаашдаа ингээд явчхаж болохгүй юм уу? Энэ хуулийнхаа 1 дүгээр заалтаар хүчингүй болгоод, 2 дугаар заалт дээрээ засагтаа эрхийг нь өгсөн заалт оруулаад тэгээд 3 дугаар заалт дээрээ 6 сарын 1-нээс эхлээд хүчин төгөлдөр гэсэн ийм байдлаар явж болохгүй юу гэсэн ийм асуулт байна.

**Ц.Даваасүрэн:** Хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэхгүй байгаа учраас таны зарчмын зөрүүтэй саналыг хураалгах боломжгүй. Тайлбар авахгүй. Яагаад гэвэл энэ чинь хуулийн төслийн үзэл баримтлалтай нь нийцэхгүй байгаад байна шүү дээ.

Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Гишүүнээ энэ Хүнсний тухай хуульд заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын зөвлөл стратегийн гурил, үр тариа, түүний үр, хүнсний улаан буудай, ундны ус, экспортод гаргах мал, махны тоо, сүү, импортоор авах хуурай сүү эд нар гээд стратегийн гол хүнс дээр ингээд зохицуулалт хийгээд явдаг, эрх нь байгаа, үүрэг нь ч байгаа.

Хамгийн гол нь сая хууль оруулаад энд түгжээд хаячихсан болохоор тэр зохицуулалт үйлчлэхээ больчихоод гацаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийг хүчингүй болгочиход бид Хүнсний тухай хуульд заасны дагуу Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөө Ерөнхий сайд нь ахлаад, холбогдох байгууллагуудыг нь оруулаад зохицуулаад л явчихна.

Нөгөө талаас тэр үнэ өссөн гээд яриад байгаа зүйл дээр ийм, бодит байдал дээр юу болсон шүү. Энэ шатахуун 47 хувийн өсөлт хийгээд, төгрөг рублийн харьцаа дээр маш хүчтэй 50 хувийн сулралт үүсээд, тэгээд манай дотоодод юу үүссэн гэвэл тэр 23 оны намар улаан буудай түрүүн дээрээ соёолоод нөгөө болц нь гүйцээгүй байхад маш их хэмжээний чийг бороо, үргэлжилсэн бороон дээр дахин соёололт үүсээд, тэгээд тэр Орос, Украины дайны асуудал гэсэн ийм мэтийн зүйлүүд их хүчтэй нөлөөлсөн.

Ер нь Засгийн шуурхай байдлыг хангаад яваад байвал олон зүйлийг урьдчилан сэргийлж болно. Тэгэхээр бид тэр эрхээ л олоод авчихвал асуудал байна. Дахиад хэлье. Энэ тариаланчид хуйвалдах бололцоо байхгүй, гурилын үйлдвэр хуйвалдах бололцоо байхгүй гэдгийг их сайн ойлгоод, тэгээд улаан буудайн нөөц бүрдүүлэх талаа ирэх оны төсөвт оруулаад ирэхэд сайн ойлгоод ингээд явчихвал эвтэйхэн болчихоор ажил байгаа юм л даа гэж.

**Ц.Даваасүрэн:** Мэндсайхан гишүүн татчихсан тийм ээ? Мэндсайхан гишүүн татсан. Гишүүд асуулт асууж дууслаа.

Ер нь төсөв, татварын асуудал бол Их Хурлын онцгой бүрэн эрх учраас Засгийн газарт өгье гэдэг ийм үгийг гишүүд их яримааргүй байгаа юм. Их Хурал бас эрхээ эдэлдэг байх ёстой. Хамаг юмаа өгөөд дууссан шүү дээ. Сайд гишүүдэд хариуцлага тооцдог байснаа өгөөд л дуусчихсан. Засгийн газар мундаг ажилладаг болно гэсэн яг хэвээрээ байна. Тэгээд ингээд Их Хуралд байгаа бүх юмнуудаа өгөөд байдгаас болоод л бид Их Хурал нь хүчгүй, Засаг нь олигтой сайжирч байгаа юм байхгүй ийм юм харагдаад байгаа байхгүй юу. Тийм учраас татвар, төсвийн асуудал бол Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал. 2 дугаар зүйл дээр асуулт асууж дууслаа.

2 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн байна. Уг саналыг та бүхэнд танилцуулж, хураалгана.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл. Хуулийн төслийн хэрэгжих хугацааны үйлчлэлтэй холбогдуулаад өөрчлөх тухай. Одоогийн хуулийг болохоор 4 сарын 1-нээс гэхсэн байгаа учраас боломжгүй. Яагаад гэвэл өнгөрчихсөн. Саналын томъёоллыг та бүхэнд танилцуулъя.



2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төслийн 2 дугаар зүйлийн “25 оны 4 дүгээр сарын 1-ний” гэснийг “25 оны 5 дугаар сарын 20-ны” гэж өөрчлөх. Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг дуусангуут 2 хоногийн дараагаар үйлчлэхээр ийм санал оруулж байгаа юм.

2 дугаар зүйлийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг, санал гаргасан Даваасүрэн, би гаргаж байна. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 28 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 57.1 хувиар санал дэмжигдсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгээс Дэгийн тухай хуулийн 45.5-д заасны дагуу “Хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн санал гаргаж, тогтоолын төслийн талаар санал ирүүлсэн байна. Бадамсүрэн гишүүн тайлбарлаж үг хэлэх юм уу? Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

**М.Бадамсүрэн:** Ер нь би ойлгохдоо энэ хавар Засгийн газраас аливаа зүйлийн үнэ тариф нэмэхгүй, татвар нэмэхгүй гэдэг ийм шийдвэр гаргасан гэж ойлгосон. Гэтэл энэ оруулж ирж байгаа бодлого бол яг энэ гаргасан шийдвэртэйгээ нийцэхгүй бодлогыг оруулж ирж байна гэж ойлгож байгаа юм.

Тийм учраас энэ 15 хувийг эргэж гаалийн албан татвар, импортын татвар гурил дээр тогтоох, тэжээл дээр 5 хувь тогтоох гэдэг шийдвэрийн үр дүнгээр гурил, тэжээлийн үнэ өсвөл яах вэ гэдэг айдас бол үнэхээр иргэдэд байгаа. Манай тойргоос олон сонгогч, иргэд энэ асуудлаар байр сууриа илэрхийлж, төлөөлөлдөө саналаа илэрхийлээд байгаа учраас би энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргасан гэдгийг хэлэх нь зүйтэй.

Тэгээд түрүүн Мөнхбаясгалан гишүүн хэлж байна. Энэ үг, үйлдэл хоёр бол нэг байх ёстой. Тийм учраас би чуулганы хуралдаан дээр энэ байр сууриа илэрхийлсэн. Тэгээд тэр үүднээсээ энэ дээр бол энийгээ үйлдэл хийж энийгээ санал хураалгая гэсэн саналтай байгаа. Тэгээд саналаа яаж өгөх нь мэдээж Байнгын хорооны гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Ер нь бол одоогийн үг хожмын гэрч гэдэг үг байдаг. Тэгэхээр одоо хэлж байгаа, гаргаж байгаа энэ санал болгон ирээдүйд үнэ өсвөл яах вэ гэдэг айдастай иргэдэд хариулт өгөх ёстой гэж үзэж байгаа юм.

Тийм учраас одоо энэ гаргаж байгаа гол шийдвэрийн үр дүнгээр иргэдийн амьжиргаанд нөлөөлөх үү, өрх айлын зарлагыг энэ нэмэгдүүлж, иргэдэд энэ хүнд нөхцөлд тарифын том өрсөлдөөн, дэлхийн том гүрнүүдийн энэ нөхцөл байдалд Монголын ард түмний иргэдэд валютын ханш өсөж байгаа энэ хүнд нөхцөлд нөлөөлөх үү гэдэг айдас бол үнэхээр байгаа. Яг үнэндээ ингээд зарим хүмүүс яриад байгаа юм. Энэ бол нэг их гурилын авч байгаа өрх айлын хэрэглээ бол тийм өндөр биш гээд. Үгүй шүү дээ, энэ чинь бага, дунд орлоготой иргэдэд, ялангуяа амьжиргааны түвшин доогуур орлоготой иргэдэд энэ гурилын үнэ гэдэг чинь асар том нөлөө үзүүлнэ.

Өнөөдөр бид өөрсдийн авдаг цалин шигээ бодож болохгүй байхгүй юу. Тэр жирийн иргэдийн, бага орлоготой иргэдийн амьдралд гурилын чинь үнэ маш их нөлөөлөх учраас энийг яах вэ гэдэг асуудал байгаа. Тийм учраас зарчмын хувьд

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

бол энэ үндэсний үйлдвэрлэлээ дэмжихийн талд бол байгаа. Энэ бол 100 хувь. Энэ бол зөв үндэсний аюулгүй байдал. Гэхдээ тэр өмнө жил одоогоос ганцхан жилийн өмнө яригдсан тэр Идэрбат гишүүний хэлээд байгаа тэр монопол энэ үйлдвэрүүд чинь үгсэж үнээ нэмээд байна шүү дээ гээд, энэ дээр ямар хариуцлага тооцсон юм бэ, үнэн юм уу, худлаа юм уу? Тэрийг нь яг үнэндээ нээрээ олон нийтэд гаргаж энийг тавих хэрэгтэй.

Тэгэхгүй бол нэр төрийг нь цайруулах, эсвэл энийг үнэн юм байна гэдгийг нотлохгүй бол зарим гурилын үйлдвэрийн захирлууд тэр үед ярьж байсныг би санаж байгаа. Ер нь ингээд үзэлцэнэ шүү л ухааны юм яриад байсан шүү дээ. Тэгээд ингээд энэ үзэлцэж байгаад нь дийлэгдэж байгаа юм байна л даа Монголын төр. Энэ төрийн гарч байгаа шийдвэр бол хүчтэй байх ёстой, энийг хүн болгон дагадаг байх ёстой, энэ нь үр дүнгээ өгдөг байх ёстой гэж би бол энэ парламентын гишүүнийхээ хувьд бол үзэж байна.

Тийм учраас энэ саналыг та бүхэн ойлгож дэмжиж өгөөч гэдгийг хүсээд, энэ Засгийн газарт үнэ тогтворжуулах эрхийг өгөхгүй гэж бас зарим гишүүн үзэж байна. Зарим нь өгье гэж байна. Энхбаяр сайдын энэ эрхийг авъя, шатахуунтай адил гэдгийг бол би бодлогын хувьд дэмжиж байгаа. Энэ бол уян хатан байх ёстой, зөв шүү дээ. Тэгэхгүй ингээд хатуу бариад. Байнгын хорооны даргын хувьд бол энэ бас энэ бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал гэж байгаа. Ингээд Байнгын хорооны дарга, сайд хоёрын байр суурь зөрүүтэй байгаа учраас энэ дээр энэ миний гаргаж байгаа санал бол хамгийн оновчтой болох юм байна гэж бодож байна.

Ямар санал вэ гэхээр үндсэндээ товчхон хэлбэл болзолтойгоор энэ татварыг эргэж сэргээж тавихыг дэмжье гэдэг санаатай. Өөрөөр хэлбэл, 6 сарын хугацаанд Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээгээр энэ гурилын үнэ өсвөл Засгийн газар яаралтай горимоор энэ гурилын импортын татварыг эргэж тэглэх асуудлаа оруулж ирдэг ийм уян хатан механизмыг бид нар энэ дагалдуулж тогтоол гаргаж, Улсын Их Хурлаас Засгийн газарт даалгавар өгөөч гэж байгаа юм.

Ингэвэл салбарын сайдад Энхбаяр сайдад ч гэсэн амар. Гурилын үйлдвэрүүдтэйгээ та нар үнээ нэмэхгүй байх талаар энэ дээр хамтарч ийм бодлого төрөөс, хувийн хэвшлээс, үндэсний үйлдвэрлэлээс, тариаланчдаас хамтарч хэрэгжүүлэхгүй бол 6 сарын дараа үнэ өсвөл дахиад энэ татвар чинь орж ирэх нь байна шүү гэвэл тэр гурилын үйлдвэрүүд чинь бас нэг юм бодно шүү дээ. Бид нар яаж энийгээ үнээ өсгөхгүй байх вэ.

Төр нөгөө талаасаа ч гэсэн сайдын хэлээд байгаа тэр 100000 тонн улаан буудайг нөөцлөх, энэний эх үүсвэрийг гаргах, энэ эрэлт, нийлүүлэлтийн тухайн үед намар тариа тариад илүү гарснаа борлуулж чадахгүй байдаг энэ нөхцөл байдал дээр нь дэмжлэг, туслалцаа үзүүлж тариалангийн аж ахуйн нэгжүүдээ чадавхжуулах, улмаар экспортод гаргахад нь дэмжих, зах зээлийн олон сонголттой болгох гээд олон зүйл дээр энэ 6 сарын хугацаанд үнэ нэмэгдвэл дахин оруулж ирнэ гэдэг зүйл нь аль, аль талдаа том сануулга, сэрэмжлүүлэг болж төрөөс гарч байгаа энэ шийдвэрийн хамгийн зөв хувилбар болох болов уу гэж бодож дэвшүүлж байгаа юм. Тэгээд энийг хүлээн авч, санал хураалгаж байгаа Байнгын хорооны даргад талархсанаа илэрхийлье. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Ц.Даваасүрэн:** Бадамсүрэн гишүүний гаргаж байгаа Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 2 заалттай юм байна лээ. Би та бүхэнд бас агуулгыг нь танилцуулчихъя. 1 дүгээрт Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээллийн 6 сарын дунджаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын үнэ өссөн тохиолдолд гурилын импортын албан татварыг чөлөөлөх тогтоолын төслийг нэн даруй өргөн барих, 2 дахь заалт нь малын тэжээлийн импортын гаалийн 50 хувийн албан татвараас чөлөөлсөн харилцааг хэвээр үлдээдэг гэсэн ийм заалттай тогтоолын төслийг хэлэлцүүлж өгөөч гэж байгаа юм байна лээ. Бадамсүрэн гишүүний гаргасан саяын агуулга, хэлсэн агуулга бүхий Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

28 гишүүнээс 7 гишүүн зөвшөөрч, би дэмжсэн шүү, минийх эсрэг гарчихлаа, 25 хувийн саналаар уг тогтоол дэмжигдсэнгүй. Хэлэлцэх нь дэмжигдсэнгүй.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцогдох хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцогдох хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хороодоос гарах санал, дүгнэлтийг танилцуулах гишүүн байна уу?

Цогтбаатар гишүүн танилцуулъя. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд манай Байнгын хорооны гишүүд үлдээд, дахиж бүртгүүлнэ. Тэгээд дараагийн 2 асуудал хэлэлцээд, манай Байнгын хороо дуусна. Хэлэлцэх, хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

11.18 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Д.ОТГОНДЭЛГЭР**

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ